



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/04

Цагаан-Овоо

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6.1, 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Засаг даргын орлогч
Гишүүд:	Санхүү албаны дарга Байгаль орчны хяналтын байцаагч Н.Ганцэцэг (Иргэний төлөөлөл) Нийгмийн бодлогын мэргэжилтэн Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Г.Алгирмаа (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл)

2. Төсвийн тухай хууль, болон бусад хууль тогтоомжийг мөрдөн хариуцсан ажилдаа идэвх зүтгэл гарган ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 27 -ны өдрийн А/13 тоот захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

4823010013